# АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

**2017-2018 он**

## Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт

Аймгийн хэмжээнд 2017 онд" Авлигын эсрэг хууль"-ийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр 17 зорилт 49 хэрэгжүүлэх үйл ажиллагаа төлөвлөснөөс ЭМС-ын хэмжээнд холбогдох заалтын хүрээнд 9 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

**1.** Сургалт соён гэгээрүүлэх, эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр:

- Хууль зүй дотоод хэргийн яам, АЗДТГ-аас зохион байгуулсан "Захиргааны ерөнхий хууль"-ийн сургалтанд ЭМГ-ын төрийн захиргааны 13 албан хаагч хамрагдсан. Хуульч, өмгөөлөгч Ганбатын "Анагаахын эрх зүй" сэдэвт сургалтанд эрүүл мэндийн салбарын 167 хүн хамрагдсан.
- "Багш шавийн эрдмийн уулзалт"-ын хүрээнд Эрүүл мэндийн салбарын 520 эмч, эмнэлгийн мэргэжилтэн эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа, шалтгаан, сургамж, сэргийлэх арга зам сэдэвт сургалтанд хамрагдсан.
- "ЭМГ, БОЭТ, Эрдэнэт сувилалын цогцолбор, Медипас эмнэлэгүүдэд "Байгууллагын ёс зүй", "Харьцаа хандлага" сэдвээр нийт 358 хүнийг хамруулсан сургалт зохион байшуулсан.
- Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн ажилтнуудыг чадавхижуулах "Хууль эрх зүйн орчин, хэрэглэгчийн эрх" сэдэвт сургалтыг зохион байгуулж 35 хүнийг хамруулсан.

2.Төрийн үйлчигээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хамтран ажиллах, төрийн ачааллалыг бууруулах чиглэлээр:

- Эмнэлгийн аюултай хог хаягдлыг зайлуулах үйлчилгээг МНЦО ХХК-ын "Ногоон ариусал" ТББ-аар ЭМГ, Баян-Өндөр сумтай хамтарсан гэрээгээр гүйцэтгүүлж байна. Энэ үйл ажиллагааг дэмжих чиглэлээр ЭМГ-аас хог хаягдалд зориулсан автомашиныг хүлээлгэн өгч, БОЭТ-ийн байрны түрээсээс чөлөөлсөн.
- Эрдэнэтийн эрүүл иргэн ТББ-ын "Элэгний вирусыг эрт илрүүлэх" үйл ажиллагааг дэмжиж орон нутгаас 14.5 сая төгрөгний санхүүжилтийг хийснээр 1350 иргэнд В,С вирусын шинжилгээ үнэ төлбөргүй хийж, 1127 хүнийг В вирусын эсрэг вакцинд хамруулсан.
- Аймгийн ИТХурлын 5/03 дугаар тогтоолоор суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, улирлын чанартай гэр сувилалд орон нутгаас 15 сая төгрөг батлагдаж, "Уян чагнуур" ХХК зорилтот бүлгийн 5 хүртэлх насны 150 хүүхдийг хамруулан эмчлэн эрүүлжүүлсэн. Гэр сувилалын үйл ажиллагаанд ЭМГ-аас 5 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын баг томилогдож, эрсдэлийн үнэлгээ хийж зөвлөмжийг өгч гүйцэтгэлийн хяналтыг МХШ-тай хамтран хэрэгжүүлсэн.
- Гэр бүлийн хүчирхийлэлээс хамгаалах тухай хуулинд зааснаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэд, хүүхэд, үл ойшоох хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эмнэлэг түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ буюу хамгаалан тусгаарлах байрыг Оюу сэтгэц наркологийн ортой эмнэлгийг түшиглэн байгуулсан.

**3.** Дотоод хяналтыг сайжруулах, ажлын гүйцэтгэл бүтээмжийг сайжруулах, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, ЭМБ-дхд арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

- ЭМГ-ын даргын 2017 оны А/11 тушаалаар батлагдсан хуваарийн дагуу ЭМГ-ын даргын тойрон үзлэгийг хэлтсийн дарга нар, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, тухайн чиглэл хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан БОЭТ-ийн сүрьеэгийн тасаг, Учралт баяр, Анхны Оч өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хяналт хийгдсэн бөгөөд эмнэлгүүдийн үйл ажиллагаатай танилцаж, тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэх ажлын хэсэг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, 2017 оны 06-р сарын 19-нөөс 23-ны өдрүүдэд, удирдлага зохион байгуулалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр шалгуурын дагуу хяналт үнэлгээ хийсэн. Нийлбэр дүнгээр хангалтгүй 2 ӨЭМТ, ажил сайжруулах шаардлагатай 6 ӨЭМТ

дүгнэгдсэн ба хугацаатай үүрэг өгч биелэлтийг эргэж тооцож ажиллахаар шийдвэрлэсэн.
**4.** Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу эрх бүхий 5 албан тушаалтны 2016 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд нь/ 2017 оны 2-р сард/ гарган, баталгаажуулжуулсан, 1 албан тушаалтны их хэмжээний өөрчлөлтийг 30 хоногийн дотор мэдүүлж, 2 албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг авч АТГ-т хүргүүлж мэдүүлгийг хянуулж томилсон. 2017 оны 11 сарын байдлаар нийт 16 мэдэгдэл, тайлбар, мэдээллийг бүртгэсэн.
**5.** ЭМГ-ын 2017 оны А/15 тушаалаар хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, ажиллах журмыг баталсан. ХШҮДА багийн 2017 оны төлөвлөгөөг 2 чиглэлээр 10 үйл ажиллагааг төлөвлөж, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 1-р улиралд 9, 2-р улиралд 15, 3-р улиралд 8 удирдамжит хяналт хийгдэж, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээний талаар дотоод хяналтын тайланд тусгаж, аймгийн Мэргэжлийн хяналтын газарт улирал бүр хүргүүлж байна.
**6.** МУ-ын Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолыг хэрэгжүүлэн, ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, тусламж үйлчилгээний хүртээмжийг тасралтгүй нэмэгдүүлэх, учирч болохуйц эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор:

- ӨЭМТ бүрт дотоод хяналтын ажилтан болон баг бүрдүүлж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаа.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын үйл ажиллагаанд хийсэн хяналтаар Гүйцэтгэлийн хяналт 2017 оны 11 сард хийгдэнэ.
- Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулж буй салбар зөвлөл, комисс, алба, багуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчил, дутагдалыг илрүүлж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, шийдвэрийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх зорилгоор Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын багаас ЭМГ-ын дэргэдэх 26 салбар зөвлөл, комисс, багуудад 2017 оны 07 сарын 06-наас 27-ны хооронд батлагдсан хуваарийн дагуу, зөвлөл, комисс, хороо, алба, багуудын ажиллах журам, төлөвлөгөөний хэрэгжилт, хэлэлцсэн асуудал, шийдвэрийн хэрэгжилт зэрэг шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт үнэлгээ хийж удирлагын багаар хэлэлцэн холбогдох багийн ахлагч нарт зөвлөмж өглөө.

**5.** Санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилт, санхүүгийн ил тод байдлын чиглэлээр:

- Шилэн дансны хуулийн дагуу байгууллагын веб сайт болон нэгдсэн шилэн дансны цахим мэдээллийн санд өөрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хамрагдах сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулан ажиллаж байна.
- 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, эрүүл мэндийн салбарын нэгтгэсэн санхүүгийн тайлан болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийн хамт хуулийн хугацаанд байршуулсан. Мөн 2017 оны хагас жилийн санхүүгийн тайлан, эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайланг холбогдох веб сайт болон мэдээллийн самбарт байршуулсан.
- 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, эрүүл мэндийн салбарын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт тайлан мэдээг хуулийн хугацаанд байгууллагын веб сайт болон нэгдсэн цахим сүлжээнд бүрэн эхээр нь тавьсан. Аудитын дүгнэлтээр өгсөн хугацаатай зөвлөмж, акт, албан шаардлагын хариуг тогтоосон хугацаанд Аймгийн аудитын газарт нотлох баримтын хамт хүргүүлж мэдээллийг байгууллагын веб сайтад байршуулсан.
- Эрүүл мэндийн салбарын 2017 оны жилийн төсвийг 1 сарын 10 дотор байгууллагын веб сайт болон нэгдсэн шилэн дансны цахим сүлжээнд байршуулсан ба жилийн төсөвт 2017 оны 11 дугаар сард өөрчлөлт орсон бөгөөд тухайн өөрчлөлтийг тухай бүрт нь байршуулан ажиллаж байна.8

**8.** Сангийн сайд Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 07 сарын 27 өдрийн 264/А/293 тоот тушаалаар төлбөртэй үйлчилгээний жишиг хэмжээ, журмыг шинэчлэн баталсны дагуу БОЭТ-д дээрхи тушаалтай холбоотойгоор шинэчлэх ажлыг зохион байгуулж, журмыг боловсруулах шатандаа явагдаж байна.
Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн засвар БЗА-121/17 тоот гэрээний дугаартай “Дулаан Масс” ХХК шалгарч 18,438,9 мянган төгрөгөөр дээврийн засварыг хийж гүйцэтгэсэн. Нийгмийн эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр ОР-102/2017 тоот гэрээний дугаартай “Ахин Удрах” ХХК шалгарч нийт 31 нэр төрлийн 97,8 сая төгрөгний тавилга, тоног төхөөрөмжийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж хүлээн авч цахим хуудсанд байршуулсан.
- Орон нутгийн санхүүжилтээр 2017 оны 02 сарын 15 өдрийн А/59 тоот аймгийн засаг даргын захирамжаар эмзэг бүлгийн жирэмсэн эхчүүдийг нэмэлт амин дэмээр хангахад 6,5 сая, 15,0 сая, А/74 захирамжаар цусаа бэлэглэж бусдыгаа аваръя аянд 5,0 сая, 2017 оны 04 дүгээр сарын А/180 Томуу томуу төст өвчний харуулдан тандалт дэгдэлтийн үед ажилласан ӨЭМТ-үүдийн эмч сувилагч нарын илүү цагийн хөлс 37,7 сая,

Зорилтод бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх иж бүрэн үзлэг шинжилгээ хийх, сургалт зохион байгуулахад 14,5 сая, 2017 оны 08 дугаар сарын 24 өдрийн А/483 тоот захирамжаар үер усны халдвараас сэргийлэх, халдваргүйжүүлэлт хийхэд 810,0 мянган төгрөг, А/530 тоот захирамж зорилтот бүлгийн 15-34 насны залуучуудад БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдвар, эрт илрүүлэг оношлогоо, эмчилгээнд хэрэглэгдэх эм, урвалж, оношлуурын 15,0 сая төгрөг, А/516 тоот захирамж Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаанд 3,8 сая төгрөг нийт 18,8 сая төгрөгний төсөв батлагдаж тус тус орж ирснийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлагнасан. Дэрхи үйл ажиллгаатай холбоотой эм эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа шууд гэрээг байгуулан худалдан авалтыг хийсэн. Цалингаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг тухайн сар бүр нь төрийн сангийн нэгдсэн пдрограммаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд шууд татан байршуулсан.
- Сар бүр байгууллагын данс болон тусгай шилжүүлгийн данс, байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд хийгдсэн таван саяаас дээш орлого зарлагын мөнгөн гүйлгээг төрийн сангийн нэгдсэн цахим бүртгэлээс шилэн дансны нэгдсэн цахим систем рүү шууд татан мэдээг мэдээллийн талбарт байршуулсан.

- 2016 онд ЭМГ-ын батлагдсан орон тоо 36, үүнээс ТЗ-ын 18, ТҮЭМ-5, ТҮ-ний 13 албан хаагч нийт 36 орон тоотой. 2017 онд төсвөөр 33 орон тоо батлагдаж ирсэн. Одоогоор орон тоонд ямар нэгэн өөрчлөлт ороогүй болно.

**12.** Тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам, комиссын ажлын албаны бүрэлдэхүүн, журам, шалгуур үзүүлэлт, тусгай зөвшөөрөл олголтын дэс дараалал, шинээр тусгай зөвшөөрөл хүссэн байгууллагын төсөл, бүрдүүлэх материалын жагсаалтыг www.orkhon.mohs.mn сайтын хууль эрх зүйн хэсгийн тусгай зөвшөөрөл олголтын мэдээлэлийн хэсэг мөн Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын вэб сайтын ил тод мэдээлэлийн хэсэгт тус тус байршуулсан.

Тусгай зөвшөөрөл олголтонд баримтлах эрх зүйн баримт болох 5 хууль, эрүүл мэндийн сайдын 4 тушаал, 7 стандартын мэдээлэл, сунгуулах байгуулага, нэмэлт өөрчлөлт оруулах байгуулагын бүрдүүлэх материал, төлөх төлбөрийн хэмжээ, татварын дансны дугаар зэргийг байршуулсан.

**13.** Тусгай зөвшөөрөл олгох комиссын мэдээний санг тогтмол шинэчлэн ЭМГ-ын www.orkhon.mohs.mn сайтын хууль эрх зүйн мэдээллийн хэсгийн тусгай зөвшөөрөл олгох хэсэгт байршуулж байна.

Үүнд:

- 150 аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн мэдээллийг оруулсан.
- 2012-2017 онд шинээр олгосон 59 байгууллагын бүртгэлийг оруулсан.
- 2015-2017 онд тусгай зөвшөөрөл цуцлагдсан 14 байгууллагыг мэдээллийг оруулсан. Үүнд: 6 эмийн сан, 8 төрөлжсөн клиник цуцлагдсан байна.
- 2015-2016 онд түтгэлзүүлсэн 8 байгууллагын мэдээллийг оруулсан. Үүнд: 4 байгууллагын эрх сэргээгдэж, 4 байгууллагын үйл ажиллагааг цуцалсан байна.
- 2015-2017 онд нэмэлт үйлчилгээ авсан эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг оруулсан. Үүнд: тусламж үйлчилгээний төрөл нэмэгдүүлж нэмэлтээр өөрчлөлт хийлгэсэн 7 байгууллага, нэмэлт үйлчилгээг хүчингүй болгосон 2 байгууллага байна.

2017, 2018 онд тусгай зөвшөөрөл сунгуулах 39 байгууллагын мэдээллийг оруулсан. 2017 онд сунгалт хийлгэх 13 байгууллагаас 9 байгууллагын тусгай зөвшөөрлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд доголдолгүй, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчөөгүй ажиллаж байгаа тул сунгалтыг 3 жилээр хийсэн.

**14.** Орхон аймгийн төрийн албаны салбар зөвлөлд 2017 онд 2 удаа хүсэлт гаргаж давхардсан тоогоор 9 сул орон тоон дээр ажлын байрны сонгон шалгаруулалт нээлттэй зарласан. Сонгон шалгаруулалт 1 удаа зохион байгуулагдсан уг шалгаруулатаар 3 ажлын байран дээр мэргэжилтэн томилогдон ирсэн. 2017 онд нийт 11 албан хаагч шинээр ажилд орсноос төрийн албаны сонгон шалгаруулалтаар 3, нэн шаардлагатай орон тоон дээр олон нийтэд нээлттэй зарласан сонгон шалгаруулалтаар 2 ажилтан орсон.

**15.** Худалдан авалт тендэр:

- Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн засвар /Аймгийг Засаг даргын Үндсэн чиглэлд НЭМТ-ийн дээврийн засвар хийхээр тусгагдан БЗА-121/17 тоот гэрээний дугаартай “Дулаан Масс” ХХК шалгарч 18,4 сая төгрөгөөр дээврийн засварыг хийж гүйцэтгэсэн.
- Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулахтай холбоотойгоор орон нутгаас дэмжлэг үзүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

/Аймгийг Засаг даргын Үндсэн чиглэлд НЭМТ-ийг шаардлагатай тавилга, студийн тоног төхөөрөмжөөр хангах талаар тусгагдан/ ОР-102/2017 тоот гэрээний дугаартай "Ахин Ундрах" ХХК шалгарч нийт 31 нэр төрлийн 97,8 сая төгрөгний тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж хүлээн авсан./

- Жаргалант сум эмийн тендерийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар шууд гэрээ байгуулан худалдан авалтыг хийж шууд гэрээ байгуулсан байгууллагын мэдээ мэдээллийг цахим хуудсандаа байршуулсан.
- 2017 онд БОЭТ нь нээлттэй тендер шалгаруулалтыг явуулж эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах Бамбай фарма ХХК, Орхон эм хангамж ХХК, Цахиурт нурамт ХХК-ууд тус тус шалгарсан. Тусгай зориулалтын бараа материал худалдан авах 6,8 сая төгрөг Сум бор ХХК, Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэхэд 17,9 сая төгрөг Алтан ном ХХК, Тээвэр шатахуун Петровис ХХК 44,8 сая төгрөг, Хоол хүнс мах, хуурай хүнс 239,4 сая төгрөг Эрдмит ХХК, Аз лагшма ХХК Ариун жүр ХХК, Бүрэнхайлааст ХХК-ууд тус тус шалгарсан. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Засаг даргын захирамжаар нийт 522,6 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн. Автомат дуслын шахуурга 5,9 сая Мед Монгол ХХК, Зүрхний цахилгаан бичлэг 7,5 сая Мон левиза ХХК, Гэмтлийн тасгийн их засвар 94,7 сая Их материал ХХК, Шарил хадгалах хөргөгч 9,9 сая СЭДБОСА ХХК, Мэс заслын тасгийн их засвар 174,4 сая Жинсийн орой ХХК, Джитал рентгэн аппарат 191,6 сая Сум бор ХХК, Лифтний их засвар 35,0 сая Пик-Торг ХХК-ууд тус тус шалгарч мэдээллийг байршуулсан.

**16.** БОЭТ-ийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд эмнэлгийн мэргэжилтний харилцаатай гомдол 1 ирж, гомдлын дагуу салбар хороо 3 удаа хуралдаж, эмнэлгийн мэргэжилтэнд сануулах арга хэмжээг тооцсон бөгөөд хариуг Медипас эмнэлэг, МХГ болон гомдол гаргасан иргэнд хүргүүлсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төв, Эмнэлэг сувилалын цогцолборын харилцааны хувьд алдаа зөрчил гаргасан 33 эмч, эмнэлгийн ажилтныг "Харилцааны чадварт суралцахуй" сургалтанд хамруулсан. Сургалтыг АШУҮИС-ийн Харилцааны ур чадварын тэнхимийн багш С.Наранчимэг явуулсан

**17**. Эрүүл мэндийн байгууллагууд иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг цахим, утас, хайрцаг, бичгээр хүлээн авч байна. 2018 оны эхний 10 дугаар сарын байдлаар Эрүүл мэндийн газарт нийт 96 өргөдөл гомдол ирсэн бөгөөд 17.7 хувийг талархал, 37.5 хувийг гомдол, 30.2 хувийг хүсэлт, 14.6 хувийг санал эзэлж байна. Нийт гомдлын 80.5 хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол эзэлж байна.

Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэн ЭМЯ болон Аймгийн ЗДТГ-т улирал бүр тайланг хүргүүлж байна.

2018 онд "Авлигын эсрэг хууль-ийг" хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр 14 зорилтын хүрээнд 32 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн газрын төлөвлөгөөнд 4 чиглэлийн хүрээнд 14 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж биелэлтийг холбогдох байгууллагуудад хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

**18.**Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр:

- Эрүүл мэндийн сайдын 2017 оны 06 сарын 30-ны өдрийн А/256 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2018 оны 01 сарын 11-ний өдрийн 42 дугаар тогтоолоор бүрэлдэхүүнээ шинэчлэн батлуулан ажиллаж байна.
- 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан түүний дагуу улирал тутам шаардлагатай асуудлаар хурлыг улирал тутам нийт 3 удаа хийж 14 асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргаж ажилласан.
- Ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэх чиглэлээр ЭМЯ ны ёс зүйн хяналтын хороотой хамтран хийт ЭМБ-ын 280 гару эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд Эмнэлгийн эрх зүйн зөрчил, түүний шалтгаан, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сэдэвт сургалтыг зохион байгуулсан. ЭМЯ-ны ёс зүйн хяналтын хорооны дарга 2 гишүүниг урьж ЭМБ-ын ёс зүйн хороодын үйл ажиллагаатай танилцуулан арга зүйн зөвлөмжийг өгүүлсэн.
- ЭМБ-ын удирдлагуудыг хамруулсан ЭМГ-ын дарга, БОЭТ-ийн захирал, ӨЭМТ-ийн ахлагч нар-8, Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн дарга нарыг хамруулсан нийт 10 удирдах албан тушаалнуудад 4 цагийн Ёс зүйн харилцаа хандлага, сонирхлын зөрчлийн талаарх сургалтыг зохион байгуулсан.



**3.** Орхон аймгийн БОЭТ-ийн ХНА-аас зохион явуулдаг “Дасан зохицох хөтөлбөр” нь шинээр ажилд орж байгаа ажилтаны хамт олон, байгууллагын соёлд дасан зохицож үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлдэг баримт бичиг юм.
Дадлагажуулагч ажилтанд 3 сарын хугацаатайгаар дадлагажуулж ажиллах бөгөөд дадлагажих явцаж, сургалт, байгуулага, бүтэц зохион байгуулалт, хамт олон, тоног төхөөрөмжтэй танилцахаас гадна ажил үүрэгтэй холбоотой байгууллагад мөрдөгддөг дүрэм журам, байгууллагын дотоод журамтай танилцаж, ХАБЭА зааварчилгаа өгөх, эрүүл мэндийн үзлэгт орно.
Эхний хагас жилийн байдлаар нийт 106 шинэ болон залуу эмч, эмнэлгийн ажилтаныг дасан зохицох хөтөлбөрт хамруулж, 5 удаагийн сургалтанд хамруулаад байна.
ХТХ-ийн 23-р зүйлийн дагуу Туршилтын болон дагалдан ажиллуулах хугацааны дууссан өдөр тус дадлагажигч ажилтны сурсан зүйлс, эзэмшсэн байх ур чадваруудыг 0-5 хүртэл оноогоор үнэлж дүнг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг гаргадаг.
**4.** 2018 онд Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, бүртгэж хянаж хуулийн хугацаанд 6 албан хаагчдын материалыг явуулсан. Мөн Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын 2 албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг АТГ-ын дүн шинэжилгээний албанд санал авахаар холбогдох материалиудыг хүргүүлж, санал ирүүлсэний үндсэн дээр томилгоо хийгдсэн.
Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай дэвтэрт бүртгэлийг цаг тухайд нь хөтлөн ажиллаж байна.
**5.** ЭМГ-ын нийт 28 мэргэжилтэн албан хаагч нарт Тагнуулын газрын ахлах мэргэжилтэн “Монгол улсын төрийн болон албаны нууцын тухай хууль”-ийг сурталчилах, таниулах зорилгоор 5-р сард зохион байгуулж санал бодлоо солилцож үр дүнтэй сургалт болсон.
Мөн Аймгийн ЗДТГ-ын төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран 11-р сард ЭМС-ын Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадвар, шударга байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахаар төлөвлөгдөж байна.
**6.** Эрүүл мэндийн газрын албан хаагчид нь төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэмийг баримтлан мөрдлөг болгон ажиллаж байна.
Төрийн бодлогын залгамж, тогтвортой байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх үүднээс төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэж, нэр дэвшүүлсэн төрийн мэргэшсэн 1 албан хаагчийг Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэний дагуу ажлын байранд нь томилсон. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын дагуу Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, төрийн албаны туршилтын хугацаанд ажлын төлөвлөгөөний биелэлт, мэргэжлийн түвшин хангалттай сайн үнэлгээ авсан 3 мэргэжилтэнг 2018 оны 05 сарын 24-ний өдөр Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсэн.

**7.** 2018 онд Эрүүл мэндийн газарт шинээр ажилд орсон 3 албан хаагчдад “Албан хаагчийн үйлчилгээнд тавих шаардлага” CS61-0020-2015 стандартыг танилцуулан мөрдөн ажиллахад хяналт тавин ажиллаж байна.
Эрүүл мэндийн газрын албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулан цаг бүртгэх машинаар албан хаагчдын цаг ашиглалтыг хянаж, улирал бүр байгууллагын шуурхай дээр танилцуулан цаг ашиглалтыг сайжруулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.
**8.** Эрүүл мэндийн газарт 2018 оны эхний 9-р сарын байдлаар иргэдээс 84 санал, гомдол, хүсэлт ирүүлснийг цаг тухайд нь шийдвэрлэж, иргэдийн санал хүсэлтийг бичгээр, 11-11 төвөөр, цахимаар, утсаар гэсэн 3 чиглэлээр хүлээн авч байгаа нь тэдний цаг завыг хэмнэж, өргөдөл, гомдол, санал хүсэлтыг цаг алдалгүй түргэн шуурхай шийдвэрлэхэд маш их нөлөө үзүүлсэн бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чанар, сэтгэл ханамж дээшилсэн.
**9.** Үйлчлүүлэгч-Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжид судалгаанд 1500 үйлчлүүлэгчийг оролцуулан судаллаа. Үүнд: БОЭТ-ийн 12 тасаг нэгж- 660, Өрх, сумын эрүүл мэндийн 9 төв- 280, Хувийн хэвшлийн 11 эмнэлэг- 460, Медипас төв эмнэлэг 50, Эрдэнэт сувилал цогцолборын 50 үйлчлүүлэгч тус бүр хамрагдсан.
Нийт үйлчлүүлэгчдийн 76,7% сэтгэл ханамжтай байна. Дээрхи үзүүлэлтэнд ХХЭМБ хамгийн өндөр 90,3% үнэлэгдсэн байна. Эрүүл мэндийн салбарын хувьд энэ багцад өндөр сэтгэл ханамжтай байгаа үзүүлэлт нь “Сувилагчийн пост нь хэний ч нүдэнд ил , тохитой ээлтэй орчин байдлаар тохижуулагдсан” байна гэж дүгнэсэн байна. Нэг дүгээр багцийн сэтгэл ханамжгүй үзүүлэлт “Тарилгын аюулгүй байдлыг хангах талаар сургалт байнга зохион байгуулахгүй байна” гэж нийт үйлчлүүлэгчийн 16% нь дүгнэсэн байна.










Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал буюу 2 дугаар багц 11 асуумжаар үнэлгээ хийгдсэн. Тус багцанд нийт үйлчлүүлэгчдийн 64,5% нь сэтгэл ханамжтай байна. Хоёрдугаар багцанд хамгийн өндөр үнэлгээ авсан эрүүл мэндийн байгууллага нь Медипас төв эмнэлэг байна. Хоёрдугаар багцад “Оношлогооны чанар, аюулгүй байдал, Эмчилгээний чанар, аюулгүй байдал”-д нийт үйлчлүүлэгчийн 27,3% нь сэтгэл ханамжгүй гэж дүгнэсэн байна.
Тэгш байдал, ашиг сонирхол буюу 6 дугаар багнанд нийт үйлчлүүлэгчдийн 81,7% сэтгэл ханамжтай байна. Энэхүү багцанд хамгийн өндөр үнэлгээ авсан байгууллага нь Өрх, сумын эрүүл мэндийн төв бөгөөд тэгш байдал, ашиг сонирхолын зөрчилгүй эрүүл мэндийн байгууллага гэж дүгнэсэн байна.
**10.** Шилэн дансны хуулийн хэрэгжилт, төсвийн ил тод байдлыг хангах үүднээс байгууллагын цахим веб хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим систетд төсвийн орлого, хандив тусламжийн орлого болон түүний зарцуулалтын тайлан мэдээг тухай бүрд нь байршуулан олон нийтэд ил тодоор мэдээллэж байна. Шилэн дансны мэдээлэлд хуульд заасан мэдээ тайлан, зарцуулалт, гүйцэтгэл, бусад холбогдох хавсралт материалыг PDF файлаар давхар хавсарган байршуулан ажиллаж байна. Байгууллагуудын ил тод байдал нэмэгдэнэ.
**11.** ЭМГ, БОЭТ, Медипас төв эмнэлэг, ӨЭМТ-үүдийн нийт 23 эмч, эмнэлгийн мэргэжилтний сул ажлын байрны зарыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулахаар хүсэлт илгээсэн. Мөн тус байгууллагууд өөрсдийнхөө цахим хуудаснаа ажлын байрны зарыг нээлттэй

байршуулсан бөгөөд ЭМГ-ын сул ажлын байрны зарыг Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай хүсэлт хүргүүлсэн. Төрийн бодлогын залгамж, тогтвортой байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх үүднээс төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-д бүртгэж, нэр дэвшүүлсэн төрийн мэргэшсэн 1 албан хаагчийг Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэний дагуу ажлын байранд нь томилсон.Аймгийн хэмжээнд Төрийн байгуулагуудтай цахим хэлбэрээр харилцах И-Оффисе систем нэвтэрч ЭМГ-ын албан хаагчид программ ашиглалтанд орохын өмнө аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан. Даргын туслах, бичиг хэргийн ажилтан, Мэдээллийн технологийн мэргэжилтэн нар аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж байгууллагын албан хаагчдад мэргжил арга зүйн зөвлөгөөг өдөр тутамдаа өгч ажиллаж байна.

2018 оны 04 сарын 25 өдрийн "Байгууллагын дотоод үйл ажиллагаанд И-Оффисе системийг ашиглах нийтлэг журам"-ыг өдөр тутамдаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаж байна.

**12**. Аймгийн хэмжээнд Төрийн байгуулагуудтай цахим хэлбэрээр харилцах И-Оффисе систем нэвтэрч ЭМГ-ын албан хаагчид программ ашиглалтанд орохын өмнө аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан. Даргын туслах, бичиг хэргийн ажилтан, Мэдээллийн технологийн мэргэжилтэн нар аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж байгууллагын албан хаагчдад мэргжил арга зүйн зөвлөгөөг өдөр тутамдаа өгч ажиллаж байна.

2018 оны 04 сарын 25 өдрийн "Байгууллагын дотоод үйл ажиллагаанд И-Оффисе системийг ашиглах нийтлэг журам"-ыг өдөр тутамдаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаж байна.

**14.** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, эрчимжүүлэх чиглэлээр 3 зорилтын хүрээнд 10 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Байгуулага дээр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж бүрэн камержуулсан. Ерөнхий боловсролын болон мэргэжлийн, дээд боловсролын сургалтын байгууллагуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисод донтох, архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг зэрэг сэдвүүдээр сургалтуудыг зохион байгуулж 500 гаруй хүүхэд хамрагдсан.

**Хавсралт 2**

| Авлигтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт | | | |
|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх | Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнах | Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр 14 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 84.0 хувийн биелэлттэй гарсан. |
| 2 | Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд ТББ, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг хэрэгжүүлэх | Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээнд хэрэглэгчийн үнэлгээ, хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх. | Үйлчлүүлэгч-Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжид судалгаанд 1500 үйлчлүүлэгч оролцлоо. Үүнд: БОЭТ-ийн 12 тасаг нэгж- 660, Өрх, сумын эрүүл мэндийн 9 төв- 280, Хувийн хэвшлийн 11 эмнэлэг- 460, Медипас төв эмнэлэг 50, Эрдэнэт сувилал цогцолборын 50 үйлчлүүлэгч тус бүр хамрагдсан. Тус судалгаанд түүвэрлэлтийн дагуу амбулатори болон хэвтэн эмчлүүлэн үйлчлүүлж байгаа нийт 1500 үйлчлүүлэгч, эмчлүүлэгчид хамрагдлаа. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгч, эмчлүүлэгчдийн 59.4% нь эмэгтэй, 40.6% нь эрэгтэй байна. Эндээс харахад судалгаанд оролцогчид насны бүлгээр 20-39 нас, 40-54 насанд, 60-70 ба түүнээс дээш насанд ойролцоо хувиар тус тус хамрагдаж, хүйсийн хувьд эмэгтэйчүүд давамгайлсан байна.<br><br>Клиник практикийн аюулгүй байдал буюу 1 дүгээр багц дотроо 4 асуумжаар үнэлгээ хийгдсэн.<br><br>Энэ багцанд нийт үйлчлүүлэгчдийн 76,7% сэтгэл ханамжтай байна. Дээрхи үзүүлэлтэнд ХХЭМБ хамгийн өндөр 90,3% үнэлэгдсэн байна. Эрүүл мэндийн салбарын хувьд энэ багцад өндөр сэтгэл ханамжтай байгаа үзүүлэлт нь “Сувилагчийн пост нь хэний ч нүдэнд |

ил , тохитой ээлтэй орчин байдлаар тохижуулагдсан" байна гэж дүгнэсэн байна. Нэг дүгээр багцийн сэтгэл ханамжгүй үзүүлэлт "Тарилгын аюулгүй байдлыг хангах талаар сургалт байнга зохион байгуулахгүй байна" гэж нийт үйлчлүүлэгчийн 16% нь дүгнэсэн байна.




Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал буюу 2 дугаар багц 11 асуумжаар үнэлгээ хийгдсэн. Тус багцанд нийт үйлчлүүлэгчдийн 64,5% нь сэтгэл ханамжтай байна. Хоёрдугаар багцанд хамгийн өндөр үнэлгээ авсан эрүүл мэндийн байгууллага нь Медипас төв эмнэлэг байна. Хоёрдугаар багцад "Оношлогооны чанар, аюулгүй байдал, Эмчилгээний чанар, аюулгүй байдал"-д нийт үйлчлүүлэгчийн 27,3% нь сэтгэл ханамжгүй гэж дүгнэсэн байна.



| | | | |
|---|---|---|---|
| | | | Тэгш байдал, ашиг сонирхол буюу 6 дугаар багнанд нийт үйлчлүүлэгчдийн 81,7% сэтгэл ханамжтай байна. Энэхүү багцанд хамгийн өндөр үнэлгээ авсан байгууллага нь Өрх, сумын эрүүл мэндийн төв бөгөөд тэгш байдал, ашиг сонирхолын зөрчилгүй эрүүл мэндийн байгууллага гэж дүгнэсэн байна. |
| 3 | | Төрийн зарим чиг үүргийг ТББ-р гүйцэтгүүлэх, гэрээ байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг тооцох. | 2018 онд хувийн хэвшлийн 11 ортой эмнэлэг, 8 ӨЭМТ-үүдтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан. Хувийн хэвшлийн гэрээнд 2018 онд эрүүл мэндийн даатгалын тасгийн гэрээг нэмж оруулсан. БОЭТ-ийн орны ачаалалыг бууруулах чиглэлээр ортой эмнэлгүүдийн гэрээнд хөнгөлөлттэй үнээр хэвтэн эмчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, ӨЭМТ-үүдийн гэрээнд 7 төрлийн шинжилгээг хийхээр тус тус тусгасан. Эмнэлгүүдийн аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгуулахаар “Ногоон ариусгал” ТТБ-тай ЭМГ, Баян-Өндөр сумтай хамтарсан гэрээгээр гүйцэтгүүлж байна.<br>Сэтгэц наркологийн Оюу эмнэлгийг түшиглэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэд, хүүхэд, үл ойшоох, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдийг түр байлгах нэг цэгийн үйлчилгээг бий болгож Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан эхний ээлжинд 6.0 сая төгрөгний санхүүжилт хийгдэж 50 гаруй иргэдийг хамруулсан байна.<br>Мөн архаг солиорол эмгэгтэй 60-70 хувь хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийг нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах эмчилгээнд орон нутгаас 2,0 сая төгрөгний дэмжлэг авч 20 хүн хамруулахаас 6 хүнийг эмчилгээнд хамруулсан.<br>“Эрдэнэтийн эрүүл иргэн” ТББ-аас Аймгийн Засаг даргын А/115 дугаар захирамжаар батлагдсан “Эрүүл Эрдэнэт хүн” хөтөлбөрийн хүрээнд бүхий 296 хүн хамруулан ЭХО оношилгоо, эмчийн үзлэг хийгдэж, элэгний хорт хавдар шинээр оношлогдсон 6, дахисан хорт хавдар 3, урьд нь оношлогдсон байсан 5, элэгний хавдарын сэжиг бүхий 9, хатууралтай 45, элэгний бэтэгтэй 1 хүнийг илрүүлж, нийт 128 хүнийг эмчийн хяналтанд оруулан ажиллаж байна. Уг үзлэг шинжилгээнд Орон нутгаас 48,0 сая төгрөгийн санхүүжилт батлагдан үйл ажиллагаанд зарцуулагдаж байна.<br>“Эрүүл Эрдэнэт хүн” үйл ажиллагааг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын А/115 дугаар захирамж гарсны аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Медипас эмнэлэг, Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Орхон аймаг дахь салбар, “Эрдэнэтийн эрүүл иргэн” төрийн бус байгууллагууд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, хэвлэлийн бага хурал хийлгэн үйл ажиллагааг эхлүүлсэн. ***“Эрүүл Эрдэнэт хүн****” хөтөлбөрийн хүрээнд 2* удаагийн аян зохион байгуулагдаж элэгний хатуурал бүхий 296 иргэдийг элэгний ЭХО оношилгоо болон эмчийн үзлэгт хамруулж 128 хүнийг хяналтад авсан. Уушгины сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх аяны хүрээнд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур 165 иргэдийг рентген харалтад хамруулж 4 тохиолдол илрээд байна.<br>Эрдэнэтийн эрүүл иргэн" ТББ-ын санаачилга, аймгийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр "Монгол уламжлал, амьдрах ухаан, ардын арга билэг" сэдэвт сургалтанд 500 гаруй хүн хамруулсан байна. “Буурлын чагнуур” болон “Энхийн хөтөч” төрийн бус байгууллагатай хамтран 29 хүнийг давтан сургалтанд хамруулж чадавхижуулсан. |
| 4 | Төрийн албан | Төрийн албан | -ЭМГ-ын даргын 2018 оны 06-р сарын 21-ны өдрийн А/37 тоот тушаалаар Төрийн албан |

| | | | |
|---|---|---|---|
| | хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх. | хаагчдад шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, шударга байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | хаагчийн ёс зүйн хороог шинэчлэн 5 гишүүнтэйгээр байгуулсан. Уг хороо нийт 3 удаа хуралдаж тодорхой асуудлаар шийдвэр гаргаж Төрийн захиргааны албан хаагчдад зориулсан ЭМГ-ын алба хаагчдыг оролцуулсан шторкыг гарган өглөө болгоны шуурхай эхлэхийн өмнө уг шторкийг явуулж байна. Мөн Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн нэрэмжит өдрийг /хуулийн тэмцээн/ 11-р сард зохион байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.<br>-Аймгийн прокурорын газрын хяналтын прокурор ЭМГ-ын 27 албан хаагчдад 3 дугаар сард "Зөрчлийн тухай хууль, Авлигын эсрэг хууль"-аар, Тагнуулын газрын ахлах мэргэжилтэн ЭМГ-ын 30 албан хаагчдад 5 дугаар сард "Төрийн болон албаны нууц"-ын тухай шинэчилсэн найруулгын хуулиар тус тус сургалтыг зохион байгуулж хуулийн мэдлэгийг дээшлүүлэн ажиллаж байна.<br>-Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Ёс зүй, хүний эрх, хууль эрх зүйн сэдэвт багц цагийн богино хугацанны Цахим сургалтыг 2018 оны 09-р сарын 21-нд зохион байгуулагдаж Эрүүл мэндийн газрын 21 алба хаагч нар оролцон "Гэрчилгээ" олгосон.<br><br>ГЭРЧИЛГЭЭ<br>№ 18 / 10 / 00[illegible]75<br>[illegible] овогтой [illegible] нь<br>Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зөвшөөрснөөр Цахим сургалт /сургалт эрхлэгч байгууллагын нэр/-аас 2018 оны 09 сарын 20-21-ны өдрүүдэд зохион байгуулсан 2 өдрийн хугацаатай<br>"Ёс зүй, хүний эрх, хууль эрхзүй" сэдэвт багц цагийн богино хугацааны сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэсэн тул ГЭРЧИЛГЭЭ олгов.<br>Олгосон багц цаг 1.0<br>Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн<br>Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны дарга<br>/Б.Амарсайхан/<br>2018 оны 09 сарын 21 өдөр<br>CERTIFICATE<br>Number 18 / 10 / 00[illegible]75<br>This is to certify that<br>Name: Sodnomdarjaa Erdenetsetseg<br>/full name/<br>has been successfully completed short term, credit training program titled;<br>"Ethics and Legislation"<br>Conducted for the period of 2 days From the date of 2018 / 09 / 20-21<br>/Year/month/date/<br>And organized by "Center for Health Development" with the approval of Center for Health Development<br>Эрүүл мэндийн сайдын 2017 оны 06 сарын 30-ны өдрийн А/256 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2018 оны 01 сарын 11-ний өдрийн 42 дугаар тогтоолоор бүрэлдэхүүнээ шинэчлэн батлуулан ажиллаж байна. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан түүний дагуу улирал тутам хурлаа тогтмол хийж, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэх сургалтыг явуулсан.<br>Тус салбар хорооны урилгаар ЭМЯ-ны ёс зүйн хяналтын хорооны дарга 2 гишүүний хамтаар 2018 оны 03 сарын 27-ны өдөр Орхон аймагт ирж ажилласан.<br>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн 3 хороо шинэчлэн байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд БОЭТ-ын дэргэдэх салбар хороо болон Медипас төв эмнэлгийн дэргэдэх хэсгийн хороодын гишүүдийг чадавхижуулах мөн Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад ёс зүйн шинэчлэгдсэн дүрэм, эмнэлгийн эрх зүйн талаарх ойлголт өгөх сургалтыг зохион |

| | | | |
|---|---|---|---|
| | | | байгуулж, үйл ажиллагаатай танилцан арга зүйн зөвлөмж өгсөн. “Эмнэлгийн эрх зүйн зөрчил, түүний шалтгаан, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдэвт сургалтыг 220 гаруй эмч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд амжилттай зохион байгуулж хамтран ажиллаа.<br>  |
| | | Ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, ёс зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулж, гишүүдийг чадавхижуулах, зөрчилд хариуцлага тооцох. | Эрүүл мэндийн газрын албан хаагчид нь Засгийн газрын тогтоолын 2010 оны 288 дугаар тоштоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баримтлан мөрдлөг болгож ажилладаг. 2018 онд ЭМГ-т шинээр ажилд орсон 5 албан хаагчдад “Албан хаагчийн үйлчилгээнд тавих шаардлага” CS61-0020-2015 стандартыг танилцуулан мөрдөн ажиллахад хяналт тавин ажиллаж байна.<br>Аймгийн прокурорын газрын хяналтын прокурор ЭМГ-ын 27 албан хаагчдад 3 дугаар сард “Зөрчлийн тухай хууль”-аар, Тагнуулын газрын ахлах мэргэжилтэн ЭМГ-ын 30 албан хаагчдад 5 дугаар сард “Төрийн болон албаны нууц”-ын тухай шинэчилсэн найруулгын хуулиар тус тус сургалтыг зохион байгуулж хуулийн мэдлэгийг дээшлүүлэн ажиллаж байна.<br>-Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн Бодлогын хэлтсээс төрийн албан хаагчдад ёс зүйн харилцаа хандлага, Гэр бүлийн харилцаа, хүмүүжил, стрессийг даван туулах, үржүүлэгч ба хуваагч гэсэн сэдвүүдээр өглөөний сургалтыг үе шаттайгаар зохион явуулж нийт Эрүүл мэндийн газрын ажилтанууд оролцон давхардсан тоогоор 61 алба хаагч нар сургалтанд хамрагдан үр дүнтэй сургалтууд болсон.<br> <br>Аймгийн ЗДТГ, Төрийн албаны зөвлөлтэй хамтран аймгийн нэгдсэн зөвлөгөөнийг 2018 |

| | | | |
|---|---|---|---|
| | | | оны 10-р сарын 26-ны өдөр 450 гаруй албан хаагч оролцон “Төрийн албаны тухай шинэчилсэн найруулга”-ын хуулийн талаар зөвлөлгөөн зохион байгуулагдаж ЭМГ-аас 20 албан хаагч санал бодол, хууль дүрмийн талаар мэдлэгээ дээшлүүлэн уг зөвлөгөөнөөс арга хэмжээнээс **УРИАЛГА** гаргасан.   ЭМГ-ын 2 ажилтан ажлын байран дээр ёс зүйн зөрчил гаргасан тул ЭМГ-ын даргын 2018 оны 08-р сарын 14-ны өдрийн Б/43 тоот, 2018 оны 05-р сарын 23-ны өдрийн А/27 тоот тушаалаар тус тус санхилгын шийтгэл ногдуулсан. |
| 5 | Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах. | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу эрх бүхий 6 албан тушаалтны 2017 оны мэдүүлгийг хуулийн хугацаа болох 2018 оны 2-р сард гарган, баталгаажуулсан. 2018 оны 05-р сард 2 албан тушаалтныг нийтийн албанд томилогдохоор урьдчилсан мэдүүлгийг холбогдох материалын хамт АТГ-ын дүн шинэжилгээний албанд хянуулж нийтийн албанд томилсон. Уг 2 албан тушаалтны Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэж баталгаажуулжсан. 2018 оны 10 дугаар сарын байдлаар нийт 11 мэдэгдэл, тайлбар, мэдээллийг бүртгэсэн. |
| 6 | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах. | Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг олон нийтэд мэдээлэх. /цахим хуудсанд байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр | ЭМГ-ын 2018 оны А/42 тоот тушаалаар хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, ажиллах журмыг баталсан. ХШҮДА багийн 2018 оны төлөвлөгөөг 2 чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөж, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 1,2-р улиралд төлөвлөгөөний дагуу ХШҮДА баг 3 удаа хуралдаж тодорхой шийдвэрүүдийг гаргаж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. 3,4-р улиралд Эрүүл мэндийн газрын дэргэдэх салбар комиссуудын үйл ажиллагаанд удирдамж гарган хяналт хийгдэж, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээний талаар дотоод хяналтын тайланд тусгаж, аймгийн Мэргэжлийн хяналтын газарт улирал бүр хүргүүлж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | мэдээлэх г.м/ | |
| | | Шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах. / дүгнэлт, акт, зөвлөмж, шийдвэр г.м | МУ-ын Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолыг хэрэгжүүлэн, ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, тусламж үйлчилгээний хүртээмжийг тасралтгүй нэмэгдүүлэх, учирч болохуйц эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ӨЭМТ бүрт дотоод хяналтын ажилтан болон баг бүрдүүлж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаа.<br>Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, өрхийн эрүүл мэндийн төвтэй ЭМС-ын 2017 оны А/05 дугаар тушаалын дагуу “Гурвалсан гэрээ” байгуулан гэрээг хагас бүтэн жилээр дүгнэн ажиллаж байна. Уг гэрээнд 6 заалтанд нэмэлт өөрчлөлт оруулсан. 2017 онд 8 өрхийн эрүүл мэндийн Гүйцэтгэлийн гэрээг дүгнэхэд 6 өрхийн эрүүл мэнд хангалттай, 2 өрхийн эрүүл мэндийн төв ажил сайжруулах шаардлагатай үнэлэгдэж, 2018 онд хангалттай үнэлэгдсэн 6 өрхийн эрүүл мэндийн төвтэй нэг жилийн гэрээг байгуулж, ажил сайжруулах үнэлгээтэй үнэлэгдсэн 2 өрхийн эрүүл мэндийн төвтэй хагас жилийн гэрээ байгуулан эхний хагас жилээр гэрээг дүгнэхэд 7 өрхийн эрүүл мэндийн төв 81,15%-тай хангалттай үнэлэгдэн, 1 өрхийн эрүүл мэндийн төв 77,22 хувьтай үнэлэгдсэн байна.<br>Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хяналтаар хийгдсэн зөвлөмжийг албан тоотоор хүргүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна<br>Ажил сайжруулах шаардлагатай байгаа 1 ӨЭМТ-ийг мэргэжил аргазүйн зөвөлгөө өгч, ажил сайжруулах хугацаат үүрэг даргавар өгч ажилласан. Гүйцэтгэлийн хяналт 2018 оны 11 сард хийгдэхээр төлөвлөгдөж байна.<br>Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулж буй салбар зөвлөл, комисс, алба, багуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчил, дутагдалыг илрүүлж, үйл ажиллагааг нь тогмолжуулах, шийдвэрийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх зорилгоор Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын багаас 2017 онд хяналт хийн үйл ажиллагаа нь тогтвортой бус явагддаг 13 салбар зөвлөл, комисс, багуудыг татан буулгаж, хүчингүй болгож үйл ажиллагаа нь жигдэрсэн 26 салбар комиссыг хэвээр үлдээн тушаалаар баталсан байна. 2018 онд батлагдсан 26 салбар комисс дээр 4 салбар зөвлөлийг шинээр нэмэгдэж үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. 2017 оны зөвлөмжөөр:<br>1.Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа хэт ерөнхий<br>2. Улирал тутам хуралдаж, асуудал хэлэлцэх үйл ажиллагаа алдагдсан.<br>3.Тухайн зөвлөл, баг, хорооны ажиллах журам, чиглэлд заагдсан үндсэн үйл ажиллагаанууд явагдахгүй байна /Хурлаар хэлэцсэн асуудал нь тайлан, төлөвлөгөө төдий/<br>4. Хурлын тэмдэглэл хөтлөлт стандарт бус, баталгаажилт хийдэггүй<br>5. Хурлын шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцдоггүй<br>Дүгнэлт:<br>Салбар зөвлөл, комисс, багийн үйл ажиллагаанд хийсэн хяналтаар Хангалтай 7 , Ажил сайжруулах 5, Эрчимжүүлэх шаардлагатай 1, Хангалтгүй 7 үнэлэгдлээ. Тохиолдол гараагүй тул үйл ажиллагаа явуулаагүй 2 комисс байна. Хангалтгүй үнэлэгдсэн 7 зөвлөл, комисс, багаас Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг зохицуулах, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарын салбар зөвлөл болон Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөл удирдлагын зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллагаагүй зөрчил илэрсэн.<br>Шийдвэрлэлт:<br>1.Зарим зөвлөл, баг, хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан тушаал шийдвэрийг эргэн харж эрх зүйн актыг шинэчлэх, багийн бүрэлдэхүүнд мэргэжлийн чиглэлийг харгалзан |

| | | | |
|---|---|---|---|
| | | | баг бүрдүүлэх.<br>• Баримт бичгийн нягтлан шалгах комисс<br>• Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо<br>• Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг зохицуулах, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарын салбар зөвлөл<br>• Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөл<br>2. Хэлтсийн дарга нар тухайн хэлтэст хамаарах зөвлөл, комисс, баг, хорооны үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох материалыг жилийн эцэст нэгтгэн архивт нөхөн бүрдүүлэлт хийж байх<br>3. Албан хаагчдын үр дүнгийн үнэлгээ, урамшуулалд хариуцсан зөвлөл, комисс, багийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг харгалзан тооцож байх<br>Цаашид анхаарал:<br>1.Багийн гишүүдийн оролцоог сайжруулах<br>2.Төлөвлөгөөний хэрэгжилтэнд анхаарах<br>3.Хурлын шийдвэрийг хэлэлцсэн асуудлаар гаргаж, хариуцах эзэн, хугацааг тодорхой заах, өмнөх хурлын шийдвэрийн хэрэгжилтийг тооцож байх<br>4.Хурлаар хэлэлцсэн асуудлын талаарх илтгэл мэдээллийг хурлын тэмдэглэлд хавсаргах, баримтжуулах, мэдээллийн сан үүсгэх<br>5.Хурлын тэмдэглэлийн дэвтэрийн хуудас бүрийг дугаарлах, арын хуудсанд баталгаажилт хийж байхаар зөвлөмж хүргүүлж өжилласан байна.<br>2017 оны зөвлөмжөөс гарсан дүгнэлтийн дагуу 4 салбар комисс шинээр баг бүрдүүлэн үйл ажиллагаа нь жигдэрч, дотоод хяналтын багийн төлөвлөгөөний дагуу хяналт хийгдэж явц 85%-тай байна. |
| 7 | Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх | Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлэх. | “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийн дагуу байгууллагын веб сайт болон нэгдсэн шилэн дансны цахим мэдээллийн санд өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг хамрах хүрээний хэмжээнд хуульд заасан заавал байршуулах санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулан тайланг холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. |
| | | Жилийн эцсийн санхүүгийн тайланг 04 сарын 25-ны дотор, хагас жилийн тайланг 8 сарын 15-ны дотор цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх /4 сарын 1-ний дотор/ | 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2017 оны эрүүл мэндийн салбарын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга тайлангийн хамт мэргэжлийн байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, акт, дүгнэлтийн хамт хуулийн хугацаанд байршуулсан. Мөн 2018 оны хагас жилийн санхүүгийн тайлан, эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайланг холбогдох веб сайт болон шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд байршуулсан. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 сарын 25-ны дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах | 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, эрүүл мэндийн салбарын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт тайлан мэдээг хуулийн хугацаанд байгууллагын веб сайт болон нэгдсэн цахим сүлжээнд бүрэн эхээр нь тавьсан. Аудитын дүгнэлтээр өгсөн хугацаатай зөвлөмж, акт, албан шаардлагын хариуг тогтоосон хугацаанд Аймгийн төрийн аудитын газарт нотлох баримтын хамт албан бичгээр хүргүүлж мэдээллийг холбогдох сайтад байршуулсан. |
| 8 | | Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн хэмнэлт , хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлэх. | Эрүүл мэндийн салбарын 2018 оны жилийн төсвийг 1 сарын 10 дотор байгууллагын веб сайт болон нэгдсэн шилэн дансны цахим сүлжээнд байршуулсан ба жилийн төсөвт 2018 оны 10 дугаар сард Засгийн Газрын 263, 264-р тогтоолуудыг үндэслэн өөрчлөлт орсонтой холбоотойгоор тухайн өөрчлөлтийг тухай бүрт нь байршуулан ажиллаж байна. |
| 9 | | Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах. /цахим | 1.ЭМС-т Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 160,0 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 572.5 сая төгрөг тус тус батлагдан үүнээс барилга, их засварын ажил 304,5, тоног төхөөрөмж 160,6 сая төсөл хөтөлбөр 267.5 сая төгрөг тус тус батлагдсан.<br>БОЭТ-ийн Цахилгаан үүсгүүрийн байр барихаар Орон нутгийн өмчийн газраас 40,5 сая төгрөгийн нээлттэй тендер зарлагдан “Хангай говийн хишиг” ХХК ажлыг гүйцэтгэн ашиглалтанд оруулсан.<br>БОЭТ-ийн Сүрьеэ-сэтгэцийн тасгийн их засварын ажилд Орон нутгийн өмчийн газар 263,0 сая төгрөгийн нээлттэй тендер зарлан “Сууц трейд” ХХК шалгаран ажлын гүйцэтгэл 90 хувьтай явж байна.<br>БОЭТ-ийн нярайн тасагт Орон нутгийн хөрөнгөөр 35,0 сая төгрөгийн санхүүжилтээр нярайн тусламж үйлчилгээнд шаардлагатай сурфактант-21 флакон, кофейн цитрат -20 ампул тариаг гэрээний дагуу 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Орхон эм хангамж ХХК |

| | | | |
|---|---|---|---|
| | | болон бусад хэлбэрээр хангах/ | нийлүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээний хангалт хийгдсэн.<br>БОЭТ-ийн гэмтлийн тасагт 28,6 сая төгрөгийн тархины цус харвалтын мэс заслын краниотомийн иж бүрдэл, багаж хэрэгсэл авахаар орон нутгийн өмчийн газар нээлттэй тендер зарлан “САН ХЛК” ХХК шалгарч гэрээ байгуулан бараа үйлчилгээ нийлүүлэгдэхээр болсон.<br>Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтаар Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжин нийт 102.0 сая төгрөг батлан дараах тоног төхөөрөмжүүдээр хангахаар тусгагдаж орон нутгийн өмчийн газар нээлттэй тендер зарлан 2 удаагийн нээлттэй тендер зарлагдсан боловч одоог хүртэл гүйцэтгэгч байгууллага шалгараагүй байна.<br>2.ЭМС-т гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй 2 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>-Азийн хөгжлийн банкны төслөөр БОЭТ-ийн Цусны аюулгүй байдлыг сайжруулах төсөл, Эмнэлгийн хог хаягдлын ариутгалын байр барих, БОЭТ-ийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн материаллаг баазыг сайжруулах төсөл зэрэг 3-5 жилийн хугацаатай хэрэгжиж байна.<br>- Жайка ОУБ-ын дэмжлэгтэйгээр Төгсөлтийн дараах анхан болон хоёр дахи шатлалд эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах нь” төсөл зэргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 10 | Зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын хангах. | Хуульд заагаагүй зөвшөөрөл, бүртгэл олгохгүй байх, тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт, түүнийг олгоход шаардагдах баримт бичиг, шийдвэрлэх журмын талаарх мэдээллийг ил тод болгох /цахим болон самбар бусад хэлбэрээр/ | 2018 онд аймгийн Засаг даргын А/195 дугаар захирамжаар Тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлаж, хавсралтаар тэргүүлэх болон хязгаарлах чиглэлийг баталуулсан. Тэргүүлэх чиглэлд тусгасан эмнэлгийн тусламж үйлчилгээг 2017 онд ЭМГ-ын даргын А/58 дугаар тушаалаар ажлын албыг томилсон. 2018 онд ЭМГ-ын даргын А/24 дүгээр тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. ажиллах журам, комиссын ажлын албаны бүрэлдэхүүн, журам, шалгуур үзүүлэлт, тусгай зөвшөөрөл олголтын дэс дараалал, шинээр тусгай зөвшөөрөл хүссэн байгууллагын төсөл, бүрдүүлэх материалын жагсаалтыг www.orkhon.mohs.mn сайтын хууль эрх зүйн хэсгийн тусгай зөвшөөрөл олголтын мэдээлэлийг байршуулсан.<br>Тусгай зөвшөөрөл олголтонд баримтлах эрх зүйн баримт болох 5 хууль, эрүүл мэндийн сайдын 4 тушаал, 7 стандартын мэдээлэл, сунгуулах байгуулага, нэмэлт өөрчлөлт оруулах байгуулагын бүрдүүлэх материал, төлөх төлбөрийн хэмжээ, татварын дансны дугаар зэргийг байршуулсан. |
| | | Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон | Тусгай зөвшөөрөл олгох комиссын мэдээний санг тогтмол шинэчлэн ЭМГ-ын www.orkhon.mohs.mn сайтын хууль эрх зүйн мэдээллийн хэсгийн тусгай зөвшөөрөл олгох хэсэгт байршуулж байна.<br>Үүнд:<br>– 155 аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн мэдээллийг оруулсан.<br>– 2018 оны эхэнд тусгай зөвшөөрлийн дуусаж сунгуулах байгууллагын бүртгэлийг |

| | | | |
|---|---|---|---|
| | | дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | гаргасан. Тухайн байгууллагт хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах ёстойг утасаар мэдэгддэг.<br>ЭМГ-ын мэдээлэлийн самбарт тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг байршуулсан. |
| 11 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах | Шинээр ажилтан сонгон шалгаруулах ажлыг ил тод нээлттэй байдлыг хангах /Сул орон тооны зар болон сонгон шалгаруулалт явуулах журам, сонгон шалгаруулалт явуулсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах, сонгон шалгаруулалтыг үндэслэн иргэдийг ажилд авах ажлыг зохион байгуулж хэвшүүлэх | Төрийн бодлогын залгамж, тогтвортой байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх үүднээс төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэж, нэр дэвшүүлсэн төрийн мэргэшсэн 1 албан хаагчийг Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсний дагуу ажлын байранд нь томилсон. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын дагуу Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, төрийн албаны туршилтын хугацаанд ажлын төлөвлөгөөний биелэлт, мэргэжлийн түвшингээрээ хангалттай сайн үнэлгээ авсан 3 мэргэжилтэнг 2018 оны 05 сарын 24-ний өдөр Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсэн.<br>Төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоог анх орох иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулж нөхөхөөр “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу ЭМГ-аас 10 сул ажлын байр зарлагдан www.csc.mn сайтад тавигдаад байна. Мөн ажлын байрны зарыг байгууллагын мэдээллийн самбар, вэб хуудсанд байршуулж олон нийтэд нээлттэй хүргэж байна. |
| 12 | | Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн | 2018 онд Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-д заасан үндэслэлээр буюу өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 5 албан хаагчийн нөөцийн бүртгэлийн мэдээлэл ил тод нээлттэй мэдээлэгдэж Монгол улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолын хавсралтад заасан Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх журмын дагуу албан хаагчийг сонгон шалгаруулж түр томилсон. |

| | | | |
|---|---|---|---|
| | | бүртгэлийг ил тод, нээлттэй болгох. | |
| 13 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө / 01 сарын 10-ны дотор/, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгарч чадаагүй үндэслэл шалтгааны талаарх мэдээллийг /7 хоногийн дотор/ хуулийн хугацаанд нийтэд мэдээлэх | Орон нутгийн өмчийн газраас нээлттэй тендер зарлагдан БОЭТ-ийн сүрье сэтгэцийн тасгийн их засварын ажлыг Сууц трейд ХХК шалгарч 263,0 сая төгрөгөөр, БОЭТ-ийн Цахилгаан үүсгүүрийн байрыг барих Хангайн говийн хишиг ХХК 40,5 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн.<br>Жаргалант сумын эмийн тендерийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар шууд гэрээ байгуулан худалдан авалтыг хийж шууд гэрээ байгуулсан байгууллагын мэдээ мэдээллийг цахим хуудсандаа байршуулсан.<br>2018 онд БОЭТ нь нээлттэй тендер шалгаруулалтыг явуулж эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах Бамбай фарма ХХК, Орхон эм хангамж ХХК, Цахиурт нурамт ХХК-ууд тус тус шалгарсан. Тусгай зориулалтын бараа материал худалдан авах 6,8 сая төгрөг Сум бор ХХК, Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэхэд 17,9 сая төгрөг Алтан ном ХХК, Тээвэр шатахуун Петровис ХХК 44,8 сая төгрөг, Хоол хүнс мах, хуурай хүнс 239,4 сая төгрөг Эрдмит ХХК, Аз лагшма ХХК Ариун жүр ХХК, Бүрэнхайлааст ХХК-ууд тус тус шалгарсан.<br>Орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Засаг даргын захирамжаар 152,2 сая төгрөг, тоног төхөөрөмж 275,3 сая төгрөгний хөрөнгө оруулалтыг тус тус холбогдох мэдээллийг байршуулсан. |
| 14 | Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, үйл ажиллагааг боловсронгуй болгох. | Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх цахим системийн үйл ажиллагааг сайжруулж, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх дундаж хугацааг өнөөгийн түвшнээс бууруулах | Аймгийн засаг даргын 2018 оны 04 сарын А/246-р “Журам батлах тухай” захирамжийн дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд И-Оффис системийг ашиглаж иргэдийн өргөдөл гомдлыг тухай бүрт хүлээн авч бүртгэл хяналтанд цаг хугацаанд нь холбогдох мэргэжилтэн бүрт хүргүүлж, хуулийн хугацаанд шийдвэрлэлтэнд эргэн хяналт тавьж, хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэдэд эргэн мэдээлж өргөдөл гомдлыг шийдвэрлэж байна. Эрүүл мэндийн газарт 10-р сарын байдлаар цахимаар нийт 100 санал, хүсэлт, талархал ирснийг шийдвэрлэсэн. |
| 15 | Авлигын эрсдлийг бууруулах, төрийн үйлчилгээний чанар | Төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлэх | Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд ЭМЯ-наас 2018 оны 08 сарын 15-ны өдрөөс MitroNetwork ХХК-ний бүтээсэн E-Health программ хангамж нэвтрүүлж эхэлсэн. БОЭТ-ийн 22 тасаг нэгжид E-Health программ хангамж нэвтэрч хэвийн үйл ажиллагаатай явж байна. Боловсрол соёл шинжлэх ухааны яам, ZTE ХХК-с хэрэгжүүлсэн “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд БОЭТ, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлэгдсэн утасгүй /wifi/ шилжээгээр холбогдох антенануудыг бүх Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр байршуулж, |

| | | | |
|---|---|---|---|
| | хүртээмжийг дээшлүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх | | БОЭТ-өөс нэгдсэн интернэт урсгал өгч өрхийн эмнэлгүүдэд E-Health программ хангамжийг нэвтрүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>Өрхийн эмнэлгүүдэд E-Health программ хангамж нэвтэрснээр БОЭТ-ийн цаг товлох үйлчилгээг өрхийн эмнэлгээс захиалах, шинэжилгээний захиаллага, шинэжилгээний хариуг өрхийн эмнэлгээс авах боломжтой болж иргэдийн чирэгдэл багасах давуу талтай болох юм.<br>Мөн "Цахим эрүүл мэнд төсөл"-ийг орон нутгийн хүрээнд Аймгийн ЗДТГ, ЭМГ, БОЭТ, Медипас төв эмнэлгийн удирдлагуудын хооронд хэлэлцээр хийгдэж нийт 355,0 сая төгрөгийн "ЦАХИМ ЭРДЭНЭТ- 2018" төслийг бичиж аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө Оруулалт Хөгжлийн Бодлогын Хэлтэст хүргүүлэн дараа онд хийгдэхээр саналаа хүргүүлсэн.<br>Уг төсөл нь Эрдэнэт хотын төр болон хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, эрүүл мэндийн бүхий л салбар нэгжийг хамарсан нэгдсэн программ хангамжтай болох, эрүүл мэндийн мэдээлэл солилцооны үйл явц хурдан шуурхай болоход чиглэсэн. |
| 16 | | Аймгийн Хэмжээнд төрийн албаны үйл ажиллагаанд E OFFICE программыг шинээр нэвтрүүлэх | Аймгийн засаг даргын 2018 оны 04 сарын А/246-р "Журам батлах тухай" захирамжаар батлагдсан төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд И-Оффис системийг ашиглаж байна. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд "И-Оффис системийг" ашиглах журмыг "Удирдлагын зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлэн, даргын тушаал гарган ажиллаж байна. |

**Хавсралт 3**

## Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилт

| № | Зөвлөмжийн дагуу Хэрэгжүүлэх арга хэмжээ | Биелэлт |
|---|---|---|
| 1 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 2 албан тушаалтныг хуулийн хугацаанд |

| | | |
|---|---|---|
| | этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр томилох, томилсны дараа хянуулах зөрчлийг таслан зогсоох. | хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар 2018 оны 05-р сард Авлигатай тэмцэх газрын дүн шинэжилгээний хэлтэст хүргүүлж санал ирүүлсний үндсэн дээр 2 албан тушаалтны томилгоо хийгдсэн. |
| 2 | Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргаж хэвшүүлэх, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх, түүнд тавих хяналтыг сайжруулах. | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу эрх бүхий 6 албан тушаалтны 2017 оны мэдүүлгийг хуулийн хугацаа болох 2018 оны 2-р сард гарган, баталгаажуулсан.<br>2018 оны 07-р сард 2 албан тушаалтны томилгоо хийгдэж хуулийн хугацаанд Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэж баталгаажуулжсан. |
| 3 | Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдэл гаргах, ашиг сонирлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг хэвшүүлэх, энэхүү мэдэгдэл, тайлбарын талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох. | 2018 онд нийт 11 мэдэгдэлийг дарга, салбарын ерөнхий нягтлан бодогч нар гаргаж уг мэдэгдэл тайлбар, мэдээллийг бүртгэж ЭБАТ-ын программд баталгаажуулан мэдэгдлээс зөрчил үүссэн тэмдэглэл байхгүй байна. |
| 4 | Иргэнийг хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжоор хангах, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу мэргэшлийн шалгалт өгөөгүй, төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилдог зөрчлийг таслан зогсоох. | Төрийн бодлогын залгамж, тогтвортой байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх үүднээс төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэж, нэр дэвшүүлсэн төрийн мэргэшсэн 1 албан хаагчийг Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсний дагуу ажлын байранд нь томилсон. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын дагуу Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, төрийн албаны туршилтын хугацаанд ажлын төлөвлөгөөний биелэлт, мэргэжлийн түвшингээрөө хангалттай сайн үнэлгээ авсан 3 мэргэжилтэнг 2018 оны 05 сарын 24-ний өдөр Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсэн.<br>Төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоог анх орох иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулж нөхөхөөр “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу ЭМГ-аас 10 сул ажлын байр зарлагдан www.csc.mn сайтад тавигдаад байна. Мөн ажлын байрны зарыг байгууллагын мэдээллийн самбар, вэб хуудсанд байршуулж олон нийтэд нээлттэй хүргэж байна. |
| 5 | Төрийн мэргэшсэн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэх, албан тушаалаас чөлөөлөхтэй холбогдуулан төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль бус шийдвэр гаргасан тохиолдолд бусдад учруулсан хохиролыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх асуудлыг Иргэний хууль, захиргааны ерөнхий хуулийн дагуу шийдвэрлүүлэх. | 2018 онд Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-д заасан үндэслэлээр буюу өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 5 албан хаагчийн нөөцийн бүртгэлийн мэдээлэл ил тод нээлттэй мэдээлэгдэж Монгол улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолын хавсралтад заасан Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх журмын дагуу албан хаагчийг сонгон шалгаруулж түр томилсон. |

| | | |
|---|---|---|
| 6 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” -нд хариуцан болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах, биелэлтийг хангаж ажиллах, үр дүнг цахим хуудсанд байршуулах, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх. | Авлигатай тэмцэх дэд хөтөлбөрийн хүрээнд Аймгийн хэмжээнд баталсан төлөвлөгөөний дагуу Эрүүл Мэндийн Салбарын хэмжээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр 14 хэрэгжүүлэх үйл ажиллагааний төлөвлөгөө батлуулж тодорхой ажлуудыг зохион байгуулж холбогдох заалт бүрээр гарган төлөвлөгөөний хэрэгжилт 84.0 хувийн биелэлттэй гарсан. |
| 7 | Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, мэдээллийн цахим сан үүсгэж үйл ажиллагаандаа ашиглах замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх. | Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд ЭМЯ-наас 2018 оны 08 сарын 15-ны өдрөөс MitroNetwork ХХК-ний бүтээсэн E-Health программ хангамж нэвтрүүлж эхэлсэн. БОЭТ-ийн 22 тасаг нэгжид E-Health программ хангамж нэвтэрч хэвийн үйл ажиллагаатай явж байна. Боловсрол соёл шинжлэх ухааны яам, ZTE ХХК-с хэрэгжүүлсэн “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд БОЭТ, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлэгдсэн утасгүй /wifi/ шилжээгээр холбогдох антенануудыг бүх Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр байршуулж, БОЭТ-өөс нэгдсэн интернэт урсгал өгч өрхийн эмнэлгүүдэд E-Health программ хангамжийг нэвтрүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>Өрхийн эмнэлгүүдэд E-Health программ хангамж нэвтэрснээр БОЭТ-ийн цаг товлох үйлчилгээг өрхийн эмнэлгээс захиалах, шинэжилгээний захиаллага, шинэжилгээний хариуг өрхийн эмнэлгээс авах боломжтой болж иргэдийн чирэгдэл багасах давуу талтай болох юм.<br>Мөн “Цахим эрүүл мэнд төсөл”-ийг орон нутгийн хүрээнд Аймгийн ЗДТГ, ЭМГ, БОЭТ, Медипас төв эмнэлгийн удирдлагуудын хооронд хэлэлцээр хийгдэж нийт 355,0 сая төгрөгийн “ЦАХИМ ЭРДЭНЭТ- 2018” төслийг бичиж аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө Оруулалт Хөгжлийн Бодлогын Хэлтэст хүргүүлэн дараа онд хийгдэхээр саналаа хүргүүлсэн.<br>Уг төсөл нь Эрдэнэт хотын төр болон хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, эрүүл мэндийн бүхий л салбар нэгжийг хамарсан нэгдсэн программ хангамжтай болох, эрүүл мэндийн мэдээлэл солилцооны үйл явц хурдан шуурхай болоход чиглэсэн.<br>Аймгийн засаг даргын 2018 оны 04 сарын А/246-р “Журам батлах тухай” захирамжаар батлагдсан төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд И-Оффис системийг ашиглаж байна. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд “И-Оффис системийг” ашиглах журмыг “Удирдлагын зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн, даргын тушаал гарган ажиллаж байна. |
| 8 | Сахилга, ёс зүйн зөрчил болон өргөдөл, гомдолд дүн шинэжилгээ тогтмол хийх, зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах. | Сахилга, ёс зүйн зөрчил гарсан өргөдөл, гомдол одоогоор гараагүй байна. |
| 9 | Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл, гэрээ, гэрчилгээ, төлбөр хураамж гэх мэт баримт бичиг шаардах, олгох явдлыг таслан зогсоох, хууль тогтоомжоор хязгааргүй тохиололд үйл ажиллагаа саадгүй явуулах нөхцлийг бүрдүүлэх. | 2018 онд аймгийн Засаг даргын А/195 дугаар захирамжаар Засаг даргын дэргэд ажиллах эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, комиссын даргаар НБХэлтсийн даргыг томилон ажиллаж байна. Захирамжаар тусгай зөвшөөрөл олголтын тэргүүлэх болон хязгаарлах чиглэлийг шинэчлэн гаргаж батлууллаа.<br>-2018 оны эхний улиралд тусгай зөвшөөрөлтэй холбоотой ирүүлсэн 39 аж ахуйн нэгж байгууллагын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.<br>-ЭМГ-ын дэргэдэх ажлын алба тусгай зөвшөөрөл шинээр хүссэн 9 байгууллагын төслийг хүлээн авч шаардлага хангахгүй 2 байгууллагын төслийг буцааж 7 байгууллагын төслийг |

| | | |
|---|---|---|
| | | комиссын 1-р хурлаар оруулж хэлэлцүүлсэн .<br>-2018 онд тусгай зөвшөөрөл сунгуулах байгууллагуудын бүртгэлийг гаргаж эхний улиралд 15 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж 1.800.000 төгрөгний улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлсөн байна.<br>-Тусгай зөвшөөрөл олгох комиссын 1-р хурлаар нийт 13 байгууллагын асуудлыг хэлэлцэж шинээр эрэгтэйчүүдийн өвчнийг оношилох эмчлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж үзүүлэх клиник-1, уламжлалтын өвчнийг эмчлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж үзүүлэх клиник-1, нүүр ам судлал, согог заслын клиник-1, 1-р зэрэглэлийн эмийн сан-1, Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн харъяат ЦАЭМТөв 1-р зэрэглэл нээх зөвшөөрлийг олгох, үйл ажиллагаа явуулахгүй байгаа 5 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэрүүдийг тус тус гаргаж аймгийн Засаг даргын А/256 дугаар захирамжаар баталуулаа. Мөн хурлаас 2 байгууллагын асуудлыг ажлын байр болон хүний нөөцийн хангалтгүйгээс хассан.<br>-Аймгийн хэмжээнд мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийг борлуулах эрхийг 1 ЭХНБ, 2 эмийн сан, сэтгэцэд нөлөөт эмийг борлуулах эрхийг 4 эмийн санд 3 жилийн хугацаатай олгохоор Засаг даргын А/256 дугаар захирамжаар батлуулаа.<br>-ЭМГ-ын дэргэдэх ажлын алба хуралдан нийт 3 асуудлыг хэлэлцсэн. Хурлын шийдвэр 100 % хэрэгжсэн.<br>2018 оны 10 сард тусгай зөвшөөрлийн 2-р 8 асуудлыг хэлэлцэж үйл ажиллагаа явуулахгүй байгаа Мэлмий нүдний эмнэлгийн цуцлаж, стандартын шаардлага хангахгүй Орхон 1-р зэрэглэлийн эмийн сан, хаягын шилжилтийг зөвшөөрөл олгоогүй 2-р зэрэглэлийн Тангад шим эмийн сан, клиникын бүтэц үйл ажиллагааны MNS6317:2017стандартын шаардлага хангахгүй Баясал хиймэл шүдний эмнэлгүүдийг түр хугацаагаар түдгэлзүүллээ. Байгууллагуудад ЭМГ-ын ажлын албанаас хурлын шийдврийг , зөвлөмжийн хамт хүргүүлсэн.<br>-ЭМГ-ын даргын А/24 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгох комиссын орон тооны бус шинжээч нарыг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилож, ажлын албанаас шинжээч нарт зориулсан сургалтын төлөвлөгөөг гарган батлуулж, сургалтыг зохион байгууллаа.-ЭМЯамны төрийн нарийн бичгийн даргын удирдамжит хяналтаар ЭМЯамны бодлого зохицуулалтын газрын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ЭМХТөвийн тусгай зөвшөөрлийн мэдээлэлийн нэгдсэн сан хариуцсан мэргэжилтэнгүүд орон нутагт нэг өдөр ажиллаж Орхон аймгийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын холбоодын дарга, эмнэлгүүдийн захирал нарын төлөөлийн 12 хүн, аймгийн тусгай зөвшөөрөл олгох комиссыг гишүүд, ЭМГ-ын ажлын албаны дарга, гишүүд, БОЭТ-ийн захирал нарыг оролцуулан тусгай зөвшөөрөл олголтын тэргүүлэх хязгаарлах чиглэлийн хэрэгцээний үнэлгээг хийх, цаашидын чиг хандлага, ЭМС-ын А/64 дүгээр тушаалын хэрэгжилтэнд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>-Тусгай зөвшөөрөл сунгуулах байгууллагуудад хийгдэх хяналтын удирдамжийг комиссын даргаар батлуулж, ЭМГ-ын даргын А/17 дугаар тушаалаар батлуулсан ажлын хэсэг 10 байгууллагт хяналт хийж, зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөлөл болох ХЭАХНийгэмлэгийн даргыг оруулсан.<br>-2018 онд ЭМС-ын “ Журам, жагсаалт, маягт батлах тухай” А/64 дүгээр тушаалын дагуу тусгай зөвшөөрөлтэй ажиллаж байгаа 150 байгууллагын мэдэээлэлийг 5 маягтын дагуу шинэчлэн гаргаж ЭМХТөвд хүргүүлсэн. Энэ нь цаашид нэмэлт 7 маягтаар судлагааг авах бөгөөд нэгдсэн мэдээлэлийн www.Licemed программд оруулж мэдээлэлийн нэгдсэн |

| | | |
|---|---|---|
| | | бүртгэлийн сангийн цахим программ үүсгэх бэлтгэл ажил ЭМЯаман дээр хийгдэж байна.<br>-Тусгай зөвшөөрөл олголтын ил тод байдлыг хангах хүрээнд www.Orkhon.mn сайтын ил тод линкд тусгай зөвшөөрөлтэй ажиллаж байгаа байгууллагуудын мэдээлэл, шинээр зөвшөөрөл хүссэн байгууллагуудын бүрдүүлэх материалын жагсаалт, сунгалт хийлгэх байгууллагуудын бүрдүүлэх материалын жагсаалтыг байршуулсан.<br>-ЭМЯам, ЭМХТөвд тусгай зөвшөөрөлтөй байгууллагуудыг 2014-2017 оны хооронд олгосон мэдээлэлийг хүргүүлж ажилласан. |

Хавсралт 4

| Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийн хэрэгжилт |
|---|
| 2017 онд Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлж, 2018 оны |

хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сарын байдлаар гарган АТГ-ын ажлын хэсэг орон нутагт ажиллах талаар урьдчилсан байдлаар гаргасан.

## Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэмжээг зохион байгуулсан

Ашиг сонирхолын талаар иргэд болон байгууллагуудаас одоогоор ирсэн гомдол санал бүртгэгдээгүй байна.

## Авлигын шалтгаан нөхцлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авсан

Авлигын шалтгаан нөхцлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх чиглэлээр:
1.Хуулийг сургалчлах
2. Урьдчилан сэргийлэх сургалтуудыг хийж байна

## Шилэн дансны тухай болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал.

1. 2015 оноос эхлэн жил бүр байгууллагын төсөв санхүү, тушаал шийдвэр, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэл зэргийг Шилэн дансны хуулийн дагуу байгууллагын веб сайт болон нэгдсэн шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулан ил тод мэдээлэн ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хамрагдах санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулан ил тод мэдээлэн ажиллаж байна.

Мөн улирлын шилэн дансны тайлан мэдээг хуулийн хугацаанд нь харъяалах дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

2.2017 онд 29.5 дахь заалтын дагуу алба хаагч нарт 813,1 сая төгрөг, 29.2 дахь заалтын дагуу алба хаагч нарт 460,5 сая төгрөг, Нэг удаагийн буцалтгүй /төрийн алба хаагч нарт буцалтгүй тусламж болох 300,0 мөгрөг / тусламж 8,1 сая төгрөгийг тус тус олгосон.

3.2018 онд Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтын дагуу 78 алба хаагч нарт 288,1 сая төгрөг, 29.2 дахь заалтын дагуу 9 албан хаагчдад 169,0 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон байна.

## Авлигын эсрэг сургалтад хамруулах, оролцогчдын тоо, огноо

1. “Зөрчлийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангахаар прокурорын газартай хамтран Эрүүл мэндийн газрын 30 гаруй албан хаагч нар оролцсон сургалтыг 2018 оны 03 сард Эрүүл мэндийн газрын хурлын зааланд зохион байгуулсан.

2. “Төрийн болон төрийн албаны нууцын тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”-уудаар 5-р сард Аймгийн тагнуулийн газартай хамтран 1 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 50 гаруй албан хаагч нар оролцсон үр дүнтэй сургалтыг зохион байгуулсан.

## Сургалтын явцад гарсан санал

1. Хуулийн шинэчлэгдсэн найруулгаар сургалтыг тогтмол өгч байх.
2. ЭМБ-дад хуулийн зөвлөхийг гэрээгээр авч ажиллуулах.
3. Шинээр ажилд орж байгаа ажилчдад хууль эрх зүйн хичээл заах мэдлэг олгох.

Тайлан нэгтгэсэн: ЭБАТ хариуцсан ажилтан Д.Отгондэлгэр